

**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 23 өдөр

№ 13/2023

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын заавар батлах тухай

“Компанийн засаглалын кодекс”-ийн Тавдугаар зарчмын 5.1, дахь заалтыг хэрэгжүүлэх үүднээс Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Компаний эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, уг тогтолцооныхоо үр дүнд тогтмол хяналт тавихын тулд “Эрсдэлийн удирдлагын заавар-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Эрсдэлийн удирдлагын заавар батлагдсантай холбогдуулан Аудитын хорооны дарга /А.Бакей/, Аудитын хорооны гишүүд /Ц.Наран-Учрал, Э.Баяржаргал/, Гүйцэтгэх захирал /Ж.Болд/ нарт энэхүү зааврыг дагаж мөрдөн ажиллаж, ажлын гүйцэтгэлийг ТУЗ-д тайлагнаж байхыг тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА  Л.ЭРХЭМБАЯР



“Түмэн шувуут” ХК-ийн ТУЗ-ийн
2023 оны 11 сарын 23 ний өдрийн
15/2023 тоот тогтоолын хавсралт



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компаний засаглалын кодексын хүрээнд нээлттэй хувьцаат компанийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулав.
- 1.2 Энэхүү баримт бичгийн зорилго нь “Түмэн шувуут” ХК /цаашид “компани” гэх/-ийн стратегийн болон үйл ажиллагааны зорилго, зорилтоо биелүүлэх явцад учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн улмаас гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдлийг удирдахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Эрсдэл, түүний удирдлага

- 2.1 “Эрсдэл” гэж компани зорилго зорилтодоо хүрэхэд учрах тодорхой бус байдал, үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.
- 2.2 Эрсдэлийг эх үүсвэрээр нь хамааруулан дараах ангиллаар тодорхойлон авч үзнэ.
 - 2.2.1 **Стратегийн эрсдэл:** Гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан стратеги зорилго, зорилтыг хангахад учрах эрсдлийг ойлгоно.
 - 2.2.2 **Санхүүгийн эрсдэл:** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг ойлгоно.
 - 2.2.3 **Үйл ажиллагааны эрсдэл:** Дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэлийг ойлгоно.
 - 2.2.4 **Комплайнсын эрсдэл:** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан үл нийцэл үүсэх эрсдэлийг ойлгоно.
- 2.3 Эрсдлийг үр дагавараар нь хамааруулан дараах ангиллаар тодорхойлон авч үзнэ.
 - 2.3.1 **Стратегийн түвшний эрсдэл:** Стратеги зорилго, зорилтод нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.
 - 2.3.2 **Бизнес процессийн түвшний эрсдэл:** Бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.
 - 2.3.3 **Байгууллагын нэгжүүд болон хувь хүний түвшний эрсдэл:** Бүтцийн чиг үүрэг бүхий нэгжүүдэд болон хувь хүнд нөлөөлөх үр дагавар бүхий эрсдэлийг ойлгоно.
- 2.4 “Эрсдэлийн удирдлага” гэж байгууллагын бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа юм.

Гурав. Эрсдэлийн удирдлагын зарчим

- 3.1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1 Соёлыг түгээх
 - 3.1.1.1 ТУЗ-ийн зүгээс эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлыг бий болгоход манлайлан оролцох

- 3.1.1.2 Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар журмууд нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчлэх ба компанийн удирдлага, ажилчин бүр дагаж мөрдөх
- 3.1.2 Үнэ цэнийг бүтээх
 - 3.1.2.1 Эрсдэлийн удирдлага нь компанид үнэ цэнийг нэмэгдүүлэх, компанийн бүхий л үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг байна.
- 3.1.3 Шийдвэр гаргалтанд ашиглагдах
 - 3.1.3.1 Эрсдэлийн удирдлага шийдвэр гаргалтын түвшин бүрт ашиглагддаг байх
- 3.1.4 Мэдээлэлтэй ил тод байх
 - 3.1.4.1 Эрсдэлийн удирдлага нь тодорхойгүй байдлыг ил болгох, системтэй, цаг хугацаандаа үнэн зөв мэдээлэл дээр суурилсан байна.
 - 3.1.4.2 Компанийн эрсдэлийн удирдлагын мэдээлэл солилцох ба зөвлөлдөх, хяналт ба мониторинг хийх үйл ажиллагаанд оролцох, гадаад болон дотоод оролцогч талуудын оролцоо, хувь нэмрийг хүндэтгэн үздэг байх
- 3.1.5 Чиг үүргийн хуваарилалт хийх
 - 3.1.5.1 Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх алба, нэгжүүдийн үйл ажиллагаа, эрх үүргийн хуваарилалт, оновчтой тодорхой байх
- 3.1.6 Тасралтгүй байх
 - 3.1.6.1 Компани эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог компанийн бүхий л түвшний үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах
 - 3.1.6.2 Компани нь стратеги зорилтууд, гадаад орчны өөрчлөлт, олон улсын практикт гарч байгаа эрсдэлийн удирдлагын шинэ мэдлэг, технологийг дотоод мэдээллийн систем, технологи, бодлого, заавар, журам зэрэг эрсдэлийн удирдлагын бүхий л элементүүдэд тусган байнга боловсронгуй болгон сайжруулж байх

Дөрөв. Эрсдэлийн удирдлагын үйл явц

- 4.1 Компанийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь дараах үет шаттайгаар хэрэгжинэ. Үүнд:
 - 4.1.1 Нөхцөл байдал буюу эрсдэлийг тодорхойлох ба эрсдэлийг тодорхойлохдоо:
 - 4.1.1.1 Эрсдэлийн шинж чанар- хаана, хэзээ, ямар үйл явдал
 - 4.1.1.2 Эрсдэлийн эх үүсвэр- ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа
 - 4.1.1.3 Эрсдэлийн шалтгаан- шууд болон шууд бус шалтгаан
 - 4.1.1.4 Эрсдэлийн нөлөө- үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө
- 4.2 Эрсдэлийг үнэлэх: Эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилж үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.
- 4.3 Эрсдэлийг удирдах буюу хариу арга хэмжээ авах : Эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 4.4 Эрсдэлийг удирдсан арга хэмжээг тайлагнана.

Тав. Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлт

- 5.1 Эрсдэлийн удирдлагыг компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.
- 5.2 ТУЗ нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.

- 5.2.1 Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох, батлах, түүнийг өөрчлөх
 - 5.2.2 Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батлах
 - 5.2.3 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох
 - 5.2.4 Стратегийн түвшний эрсдэлийг удирдах
 - 5.2.5 ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд хяналт тавих
- 5.3 Гүйцэтгэх удирдлага нь дараах байдлаар эрсдэлийг удирдана.
- 5.3.1 Эрсдэлийн удирдлагын бодлогын дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх
 - 5.3.2 Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах
 - 5.3.3 Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, хариу арга хэмжээ авах талаарх журмыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх
 - 5.3.4 Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтын ажилтан болон нэгжээр дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд хяналт тавих

Зургаа. Хяналт, сайжруулалт, өөрчлөлт оруулах

- 6.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, түүний хэрэгжилтэнд дотоод хяналт, Аудитын хорооноос хяналт, аудит хийнэ
- 6.2 ТУЗ нь Аудитын хорооны тайлан, дүгнэлт, зөвлөмж болон гүйцэтгэх удирдлагын саналд үндэслэн бодлогод өөрчлөлт оруулна.
- 6.3 Энэхүү баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батлана.

* * *